

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр, Мягмар гараг
Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-25
<hr/>	
<i>1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	5-25

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны
10 дугаар сарын 29-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Д.Батбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 22 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Г.Дамдинням, Б.Заяабал.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батдорж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Алтанцэцэг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа,

Р.Ринчинбазар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нармандах, мөн газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Батчимэг, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Мөнхзул, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Баттулга, Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Х.Мөнхжаргал, мөн компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХХК-ийн удирдлагын газрын дарга Г.Бадрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт Д.Гэрэлт-Од, С.Тэгшжаргал нар байлцав.

Дэд хорооны дарга Д.Батбаяр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас албан бичгийн хариу ирэхийг хүлээж байгаа тухай мэдэгдэж, хуралдаан 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 17 цаг 32 минутад завсарлаж, 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 16 цаг 22 минутад үргэлжлэв.

Төсвийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Д.Батбаяр нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Ганцэцэг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нармандах, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХХК-ийн удирдлагын газрын дарга Г.Бадрах нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Батбаяр: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.178.Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Баяндэлгэр сум/, хэрэгжих хугацаа 2019-2025 он, төсөвт өртөг 2,100.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 717.9 сая төгрөгөөр бууруулж, XVI.1.1.31.Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 11,121.7 сая төгрөг, санхүүжих дүн 5,548.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний нэрийн “24 у/м” гэсний дараа “гэрэлтүүлэг” гэж нэмж, төсөвт өртөг болон санхүүжих дүнг 717.9 сая төгрөгөөр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Батбаяр: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9
44.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Батбаяр: Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 7
Бүгд: 9
22.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Д.Батбаяр: 2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.36.Сургуулийн барилга, 320 суудал /Сүхбаатар, Түвшинширээ сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 9,618.3 сая төгрөг, санхүүжих дүн 4,555.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,219.3 сая төгрөгөөр бууруулж, Соёл амралтын хүрээлэн /Сүхбаатар, Баруун-Урт сум/, төсөвт өртөг 14,926.4 сая төгрөг, санхүүжих дүн 2,219.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.185.Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/, хэрэгжих хугацаа 2018-2025 он, төсөвт өртөг 2,160.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,800.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,300.0 сая төгрөгөөр бууруулж, Төрийн аудитын газрын байр худалдан авах /Сүхбаатар/, төсөвт өртөг болон санхүүжих дүн

1,300.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 6

Бүгд: 9

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, XVII.1.124.Олон угсаатны театрын барилга Ховд аймгийн Жаргалантын, санхүүжих дүнг 2 тэрбум төгрөгөөр бууруулж, XVI.1.1.4.Ногоон байгууламж бүхий орчны тохижилтын ажилд Ховд аймгийн Мянгад сум, Зэрэг сум, Буянт сум, санхүүжих дүн 2 тэрбум төгрөгөөр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 6

Бүгд: 9

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Дэд хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 23 минут үргэлжилж, ирвэл зохих 12 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 17 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Д.БАТБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
17 цаг 22 минут.

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Батбаяр: Дэд хорооныхоо эрхэм гишүүдэд энэ өдрийн амгаланг айлтгая. Тэгээд нэлээн 2 өдөр гацаж байж нэг юм цуглалаа. Батболд гишүүндээ бас амгаланг айлтгая. Булгантуяа гишүүн маань өнөөдөржингөө хүлээлээ. Бас танд баярлалаа гэдгээ хэлье. Мэндсайхан гишүүндээ, Цогтбаатар гишүүндээ, Ганзориг гишүүндээ, бас мөн Батсайхан гишүүндээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Дэд хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Дэд хорооны гишүүн Далайн Батбаяр миний бие байна, Ринчиндоржийн Батболд гишүүн байна, Жигжидийн Батжаргал гишүүн байна, Дамбын Батлут гишүүн чөлөөтэй юм байна. Чөлөөтэй байгаа юм байна. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн байна, Пүрэвжавын Ганзориг гишүүн байна, Гонгорын Дамдинням гишүүн болон Батжаргалын Заяабал гишүүн бас чөлөөтэй байгаа юм байна. Загджавын Мэндсайхан гишүүн байна, Банзрагчийн Түвшин гишүүний ирц орсон байна, Даваагийн Цогтбаатар гишүүн байна. Ингээд ирц хүрсэн учраас хуралдаан эхэлж байгааг мэдэгдье. Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн

даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл, Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн хороонд. Энэ юу яачихсан юм байна тээ?

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Сангийн сайд Болдын Жавхлан ирсэн байна. Монгол Улсын Ерөнхий аудитор Загджав ирсэн байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Энхбаяр ирсэн байна, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн, хөгжлийн дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Түмэндалайн Даваадалай бас ирсэн байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Лхагважавын Гангэрэл, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Жамсрандоржийн Дэлгэрсайхан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Равсалын Ринчинбазар, Монгол Улсын Ерөнхий аудитын орлогч Ядамын Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Цэвэгсүрэнгийн Наранчимэг дарга ирсэн байна, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Дэлгэрийн Энхболд дарга бас ирсэн байна, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Идэшийн Батхүү дарга ирсэн байна. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат ирсэн байна, Эдийн

засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан дарга ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Бат-Ирээдүйн Анар ирсэн байна. Анар? Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж дарга ирсэн байна, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн ирээгүй байна. Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо ирээгүй байна. Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд хаана байгаа юм? Сангийн яамны дарга нар, газрын дарга нар бүгдээрээ шүүх хуралд сууж байгаа гэж байна. Тэгвэл Дэлгэржаргал дарга бас байхгүй байгаа байх. Аан за, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Жамъяншаравын Дэлгэржаргал дарга маань ирчихсэн байгаа юм байна. Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга? Энэ сайд нь хаана байгаа юм? Танай сайд орж ирэхгүй юм уу? Танай Төрийн нарийн бичгийн дарга чинь орж ирэх юм уу? Томилолтоор явчихсан байгаа? Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын хөгжлийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ганзоригийн Батдорж байна? Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Зоригсайханы Тулга дарга ирсэн байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Цэнд-Аюушийн Ганцэцэг дарга ирсэн байна. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албаны үүргийн хавсран гүйцэтгэгч, Тамгын газрын дарга Мухраагийн Нармандах, Бямбасүрэн гэж дарга байсан тээ? Бямбасүрэн дарга чинь байхгүй байгаа юм уу? Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга Баасангийн Алтанцэцэг дарга ирсэн байна. Хурдан хурдан уншаад явчихъя. Эрүүл мэндийн даатгалын

ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга Батчулууны Батчимэг дарга байхгүй байна. Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Намчингийн Мөнхзул, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Осорын Баттулга дарга ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга Отгондэмбэрэлийн Мягмардорж дарга ирсэн байна. Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх дарга ирсэн байна. Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Лувсанвандангийн Ичинноров дарга ирсэн байна. Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ дарга ирсэн байна. Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Лувсандоржийн Гантогтох дарга ирсэн байна. Сангийн яамны Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга ирээгүй байна. Сангийн яамны Санхүүгийн зах зээлийн даатгалын хэлтсийн дарга Батбаатарын Амарбаясгалан дарга ирсэн байна. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг дарга ирсэн байна. Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Батнямын Отгонцэцэг ирсэн байна Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Чойжоогийн Гантөмөр, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Хүүгийн Мөнхжаргал, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Галбадрахын Гантулга, Дархан төмөрлөгийн үйлдвэрийн захирлыг дуудсан шүү дээ. Энэ ямар хүн ирчихсэн байгаа юм?

Би ингэсэн юм аа. Энэ хурал дээр тодорхой нэр бүхий хүмүүсийг дуудсан байгаад байгаа. Ер нь бол яг энэ төсвийг хэлэлцэхтэй холбоотойгоор маш зөв жишиг тогтоож байгаа. Манай гишүүд бол бүгдээрээ яг энэ төсөвтэй холбоотой асуудал дагуулсан асуудал болгон дээр нь бүгдээрээ асуудал гаргаж нийгэмд

таниулж, зөв чигийг тогтоож байгаа учраас энэ жишгийг бас энэ хуралдаан дээр үргэлжлүүлээд явах ёстой.

Ер нь бол энэ төсөвтэй холбоотой, төсвийн зарлагатай холбоотой асуудал дээр маш шүүмжлэлтэй хандаж маш нарийн хэлэлцэх шаардлагатай болж байгаа юм байна. Тэгээд ер нь бол төсвийн орлого нэмэгдүүлэх, тэр төсвийн зарлагыг хамгийн бага байлгах тал дээр одоо бүгд хичээх хэрэгтэй юм байна. Тэгээд энэ үүднээсээ сая энэ сүүлийн үед социал ертөнцөд гараад байгаа энэ соёл ямар яам билээ? Соёлын яамны энэчээ нэг юунууд хийгдсэн байгаа тээ? Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдад албан бичиг өгсөн. 4 сарын өмнө Спортын яам гэж байхад Бат-Эрдэнэ сайдтай Спортын яам гэж байхад, байж байгаад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд нэгдсэн. Тэгээд энэ яам нэгдсэнтэй холбоотойгоор хэдэн хүн ямар хариуцлага хүлээсэн бэ? Тэр яам нэгдэхээс өмнө 2023 онд 110 тэрбум төгрөгийн акт тавигдсан байдаг юм байна лээ. Тэгээд энэ акт тавигдсантай холбоотойгоор шинэ яаманд ажилд орохдоо хэн нь ямар ажил хийж байна вэ гэдэг асуулгыг бичгээр тавьсан. Энэний хариу ирээгүй байна. Тэгээд энэний хариуг би шаардаж байгаа.

Нөгөөтээгүүр бас, ер нь энэ зарлага тал дээрээ хариуцлагатай байя гэж байгаа учраас ерөөсөө энэ 2024 оны эхний 3 дугаар улирлын байдлаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлын дэлгэрэнгүй тайлан, мөн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгагдсан бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хүрээнд зарцуулах зардлын нарийвчилсан төлөвлөгөөг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд ирүүлнэ үү гэж бас бичгээр мэдэгдсэн байгаа. Тэгээд энийг иртэл хурал завсарлаж байна.

17.32 цаг

/2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр/

ҮРГЭЛЖЛЭЛ

2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
16 цаг 22 минут.

Д.Батбаяр: Гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе.

Ингээд 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдааныг үргэлжлүүлье.

Өчигдөр буюу 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар 28 биз дээ? Өчигдрийн хуралдаанаар тийм, дэд хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирц болон хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулчихсан байгаа.

Тийм учраас шууд ажилдаа орёе.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Эрхэм Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж,

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах, бүсчилсэн хөгжлийг дэмжих, татвар, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх, авлигыг бууруулж, хүний эрх, засаглалыг сайжруулах зэрэг эрх зүйн 14 реформыг хийж, эдийн засгийн суурийг тэлж хөгжлийг эрчимжүүлэхийн тулд 14 мега төслийг хэрэгжүүлэх зайлиггүй шаардлагатай байна.

Ирэх 2025 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарааны бүтэн жил учирсан. Ирэх оны төсвийг бүсчилсэн хөгжилд зайлиггүй шаардлагатай суурь дэд бүтцийг шийдэх, орон нутаг бие даан хөгжихөд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, Нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглүүлснээрээ өмнөх жилүүдээс ялгаатай юм.

Шинэ 30 жилийн хөгжлийн суурийг тавих томоохон төслүүдийг эхлүүлэх төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг дэмжихэд чиглэсэн 25 оны төсвийн бодлогын 3 онцлогийг дурдъя.

Нэгдүгээрт, анх удаа бүсчилсэн хөгжлийг бүрэн дэмжсэн төсөв болж байна. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 23 жилийн дараа шинэчлэн баталж, газар, түүний баялаг, түүхий эдийн нөөцийг оновчтой ашиглан, хүн ам, үйлдвэрлэлийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутгийн тэнцвэргүй байдлыг багасган хөгжлийн түвшинийг ойртуулж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх эрхэм ёсыг зорилтыг дэвшүүлсэн билээ.

Энэ хүрээнд Монгол Улсын 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтыг

бүтцийн хөгжлийг дэмжих эдийн засгийн интеграцчилал бий болгоход шаардагдах нэн тэргүүний дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд чиглүүллээ.

Өмнө нь бид хөрөнгө оруулалтыг аймаг, сумдаар жижиглэж төлөвлөдөг байсан бол ирэх 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтыг бүс нутгуудыг хөгжүүлж, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, бүсүүдэд бизнесийн орчныг сайжруулж, хөрөнгө оруулалт татах дэд бүтцийн томоохон төслүүдэд чиглүүлэхээр тусгалаа.

Ингэснээр 2028 он гэхэд Монгол Улсын хатуу хучилттай авто зам 4440 км-ээр нэмэгдэх бол, эрчим хүчний салбарт 1650мвт цахилгаан дулааны эх үүсвэр шинээр бий болж, 1519км цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

Эдгээр хөгжлийн бүтээн байгуулалтуудаас гадна бид нийгмийн салбарын төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 93 сургууль, 67 цэцэрлэг, 37 эмнэлэг, 22 дотуур байр болон соёл, спорт чиглэлийн 60, нийгмийн хамгааллын 17 төслийг ашиглалтад оруулна.

Хоёрдугаарт, хувийн хэвшлийн оролцоог татварын бодлогоор дэмжинэ. Бүсчилсэн хөгжлийг дан ганц хөрөнгө оруулалтаар улсаас шийдэх боломжгүй тул бүс нутгийн эдийн засгийн идэвхжилийг дэмжих бүсийн татварын ялгаатай бодлогыг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Энэ хүрээнд 20 гаруй нэр төрлийн татварыг бүсийн онцлогоос хамааран ялгаатай тогтоох боломж бүрдэж, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлж, бүс бие даан хөрөнгө оруулалт татах эдийн засгийн бодлогоор өрсөлдөх боломжийг бүрдүүлээд байна.

Түүнчлэн бүсчилсэн хөгжлийн зорилтод нийцсэн томоохон бүтээн

байгуулалтад хувийн хэвилийн оролцоог урамшуулан идэвхжүүлэх бодлого баримталж, томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт хийхийг уриалан дэмжсэн татварын цогц бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

Нийслэлд тулгамдсан асуудлыг Нийслэл хотод сүүлийн 30 жилд нийтдээ 11.5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байсан бол ирэх 4 жилд нийтдээ 30 гаруй их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөлөө.

Нэн тэргүүнд түгжрэл, агаар, хөрс, усны бохирдол зэрэг Нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэх зорилгоор 2025 оны төсвийн төсөлд нийслэлд анх удаа 4.5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр тусгаж байна.

Ингэснээр төвлөрлийг сааруулах, нийгмийг нийгмийн суурь үйлчилгээг 20 минутын дотор хүргэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах арга хэмжээг бодитой хэрэгжүүлэх юм.

Энэ хүрээнд Хөшигийн хөндийн туннел, “Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламжийн мега төслүүдийг Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолборыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл, метро төсөл, Туул хурдны зам, Шинэ их тойруу хурдны зам, шинэ тойрог авто замын төслүүдийг Нийслэлийн эх үүсвэр болон төр, хувийн хэвилийн түншиллээр тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Эдгээр арга хэмжээний үр дүнд агаарын бохирдол 22 орчим хувиар буурч, нийтийн тээврийн хүртээмж нэмэгдэж, түгжрэлийн асуудал шийдэгдэнэ.

Түүнчлэн 37 мянган айлын орон сууц барих дэд бүтцийг бий болгосноор ажлын байр нэмэгдэж, хувийн хэвшил бизнес хийх орчныг бүрдүүлнэ.

Монгол Улсын 2025 онд Төсвийн тухай хуулийн төсөлд туссан дээрх бодлогыг хэрэгжүүлснээр ирэх онд 83 сая тонн нүүрс, 1.8 сая тонн зэсийн баяжмал экспортлож, гадаад худалдааны нийтийн эргэлтийг 32.8 тэрбум ам.долларт, эдийн засгийн өсөлтийг 8 хувьд хүргэж, нэгдсэн төсвийн нийт орлогын хэмжээг 36.8 их наяд төгрөгт хүргэхээр тооцлоо.

Зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Батбаяр: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 24 оны 8 дугаар сарын 30-ны

өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хуулийн хүрээнд хийж гүйцэтгэн аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Тус аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилгод нийцсэн эсэхийг хянаж дүгнэхэд чиглэсэн.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагыг хангаж, Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, бүсчилсэн хөгжлийн цогц реформ, Нийслэлийн төвлөрлийг сааруулах, том төслүүдийг эхлүүлэх зорилтын хүрээнд төлөвлөгдөж, төсөвлөгдсөн байна.

Гэвч өмнөх оны төсвийн төслийн аудитор өгсөн үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн эсэхийг хянаж, үнэлэх, шалгуур үзүүлэлт тодорхойгүй хэвээр байна. Нийт зөвлөмжийн хэрэгжилт 69 хувьтай байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан шалгуурт нийцэж байгаа эсэхэд аудитор дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд,

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцэж байна.

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2025 онд ДНБ-ий 42.6 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон

тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв, санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаатай нийцэж байна.

2.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлого 33 их наяд 864.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.6 хувь, нийт зарлага 35 их наяд 790.2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт төсвийн 37.7 хувь, төсвийн суурь тэнцэл 1 их наяд 909.5 тэрбум төгрөгийн ашигтай, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 930.5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын төсвийн 2 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх, нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт тэнцвэрийн 2-оос дээш хувийн ашигтай байх, нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх, Засгийн газрын өөрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх гэсэн тусгай шаард шаардлагуудыг хангасан байна.

3.Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлалд нийцсэн боловч Улсын Их Хурлаас улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг батлаагүйгээс түүнд чиглэсэн эсэхийг харьцуулан дүгнэх боломжгүй байсныг дурдах нь зүйтэй байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд,

1.Гадаад хүчин зүйлийн нөлөөлөл, уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж нүүрсний экспорт төсөвлөгдсөн

хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, орлого тасрах эрсдэлийг тооцох шаардлагатай байна.

2.Төсвийн төслийн хамт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг өргөн мэдүүлсэн нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.

3.Засгийн газраас 2025 оны бүсчилсэн хөгжлийн хүрээнд дэд бүтцийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх зорилт дэвшүүлэн авто зам, эрчим хүч, дэд бүтцийн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь өмнөх онуудад улс бүсийн түвшинд тэргүүлэх асуудал багатай олон жижиг төсөл, арга хэмжээг улсын төсвөөр санхүүжүүлэхээр тусгаж байсантай харьцуулахад төсөл, арга хэмжээний цар хүрээ, үр нөлөөний хувьд тодорхой ахиц гарсан байна.

4.Шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлалд зөвхөн барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг хамруулж байгаа нь бусад ангиллын төсөл, арга хэмжээг орхигдуулах, тусгай шалгуур үзүүлэлтээр үнэлээгүй, шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгах тусгах эрсдэлийг дагуулж байна.

5.Өмнөх оноос шилжин хэрэгжих төсөл, арга хэмжээнээс худалдан авах ажиллагаа зарлагдаагүй, гүйцэтгэл шалгараагүй, төсөвт өртөг нэмэгдсэн зэрэг шалтгаанаар нийт 1 их наяд 168.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 430.8 тэрбум төгрөгийн 130 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаагүй байна.

6.Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг үргэлжлэх хугацаатай нь уялдуулахгүйгээр 3 жил тэнцүү

хуваарилахаар хуульд заасан нь олон жил үргэлжлэх томоохон барилга, байгууламжийн хувьд төсөвт өртгийн хэмжээнээс хамаарч тухайн жилд төлөвлөгдсөн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүй байх, нөгөө талаас санхүүжилт шаардлагатай бусад арга хэмжээний төсөв батлагдахгүй хорогдох эрсдэлийг үүсгэж байна.

7.Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байгаа нь төсөвт өртгийг үндэслэл тооцох, үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

Аудитын дүн, дүгнэлт нь үндэслэн Улсын Их Хурал, Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд дараах асуудлуудыг толилуулж байна. Үүнд,

Улсын хөгжлийн төлөвлөгөөг жилийн төсвийн төслийг боловсруулахаас өмнө баталж баймаар байна.

Дараагийн дугаарт, Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах зарчмын хүрээнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтын төсөв, арга хэмжээг төсөвт тусгахгүй байх.

Мөн Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд,

Монгол Улсын Засгийн газарт дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн чанарыг дээшлүүлж, төсвийн сахилга батыг хангаж ажиллах. Төсвийн төслийг төрийн мөнгөний бодлогод нийцүүлэн төсвийн зардлын тэлэлтээс нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг үр дагаврыг үнэлж, бууруулах арга хэмжээ авах.

Гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг төсвийн төлөвлөлтийн эрх зүйн мөн шаардлагад нийцүүлэх, төсвийн боломжит эх үүсвэр, бүх төрлийн ашигт малтмалд ноогдуулсан ашигт малтмалын ноогдол ашгийн татварыг бүрэн төвлөрүүлэх, хөгжлийн төсвүүдийг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцож, төлөвлөсөн хугацаанд чанартай гүйцэтгэхэд хяналтыг хэрэгжүүлэн төсвийг үр ашгийг нэмэгдүүлэх, геополитикийн тогтворгүй байдлын улмаас авто, бензин, улаан буудай, хүнс, эрчим хүч зэрэг манай улсын импортын голлох бараа бүтээгдэхүүний үнийг өсгөх эрсдэлтэй байгаа тул шаардлагатай стратегийн нөөц бүрдүүлэхэд анхаарах, улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд бүсүүдэд улсын хэмжээнд салбарын хөрөнгө оруулалт зэргээр байршил тодорхойгүй тусгагдсан арга хэмжээний задаргааг тусгайлан хэлэлцүүлж батлуулах.

Өмнөх онуудад хэрэгжиж эхэлсэн дуусаагүй боловч төсвийн төсөлд тусгагдаагүй төсөл, арга хэмжээний үр ашигт анхаарч, холбогдох ишидвэр гарган хэрэгжүүлэх.

Сангийн яам, хөгжлийн бодлогод нийцүүлсэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан алба хаагчдын нэгдсэн арга зүйгээр хангаж, чадавхыг нь сайжруулах, Улсын Их Хурлаар баталсан төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн төсвийн төслийг боловсруулж байх.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ноогдол ашгийг төсөвт бүрэн төвлөрүүлэх.

Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардлаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төрөл ангиллаар нь

нарийвчлан тодорхойлж, хууль журамд тусгах, тоног төхөөрөмж их засвар болон ТЭЗҮ-ийг төлөвлөх, эрэмбэлэх аргачлал, зохицуулалтыг тодорхой болгох.

Төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрийг журмын дагуу үнэлж эрэмбэлэн үргэлжлэх хугацааг нь үндэстэй төлөвлөх.

Эдийн засгийн хөгжлийн яаманд.

Цахим систем нэришлээр төсвийн төсөлд тусгасан төсөл, арга хэмжээ болон ТЭЗҮ-ийг боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцох, хянах жишиг үнийг тогтоох, холбогдох зохицуулалтыг бий болгох.

Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу аудитын зөвлөмжийг зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаад төсвийн ерөнхийлөн захирагч нар анхаарч ажиллах шаардлагатай байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Батбаяр: Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төслийн талаарх Сангийн сайдын танилцуулга болон Аудитын дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Гишүүдийн нэрсийг авч дууслаа. Цогтбаатар гишүүний микрофоныг.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүд болон Зарлагын хяналтын дэд хорооны гишүүдэд оролцож байгаа бүх хүмүүст энэ өдрийн мэнд хүргэе.

2024, ер нь өнгөрсөн хугацаанд энэ Зарлагын хяналтын дэд хороон дээр өмнөх жилийнхээ төсвийн зарцуулалт, тэр дундаа юу гэдэг юм урсгал зардал гэдэг юм уу, хяналт хариуцлага ярьж байсан хүн байна уу? Одоо тооцоо

судалгаа тан дээр хийгдэж ирүүлсэн юм байна уу, эсвэл та өөрөө хүсэлт бичээд хариу авъя гэсэн юм байна уу? Жишээлэхэд би бол тооцоод байгаа. Архангай аймаг руу нөгөө бүсийнхээ аймгууд руу аудит хийгдэж байна уу, Засаг даргын Тамгын газар дээр санхүүгийн аудит хийгдэж байна уу гэхээр 4 жил Архангай аймгийн Засаг даргын Тамгын газар дээр санхүүгийн аудит хийгдээгүй байх жишээтэй. Өнгөрсөн 4 жил юу ч байхгүй. Надад албан бичгээр тийм хариу ирсэн. Аудит хийгдээгүй.

Тэгэхээр бид нар юу гэдэг юм 2025 оны төсөв дээр бол 110 тэрбум төгрөг томилолт гээд байгаа. 111 тэрбум.

2024 оны төсөв дээр 76 тэрбум төгрөг байгаа. 76 тэрбум төгрөгөөр хэн, хаашаа, ямар томилолтод яваад, зөвхөн гадаад томилолт, хэн хаашаа яваад ямар үр дүнд хүрсэн бэ гэдгийг жишээлэхэд энд яримаар байгаа юм. Монгол улс тийм баян улс биш, 76 тэрбумаар нь асгаад сууж байх ёстой тийм төсөвтэй газар биш болчхоод байгаа юм.

Тэгээд саяхан гарсан Соёл, спорт, залуучуудын сайд өөрт нь хамааралгүй хүмүүсийг баахан гадагш нь явуулаад л хэдэн сая төгрөг, манай Хяналтын сайд өөрөө бас хэдэн хүн ийш тийш нь бас аялуулаад, зугаалуулаад л хэдэн сая төгрөг. Энэ мөнгөнүүдийг чинь уг нь жоохон арвигч, хямгач байдлаар хэн нэгэн хянаж байгаад арай жоохон бодитой, үр дүнтэй ажилдаа хиймээр байгаа юм.

Жишээлэхэд, түрүүчээсээ энэ сургууль, цэцэрлэгийн асуудал чинь зөндөө энд тэнд сургууль байхгүй байна, цэцэрлэг байхгүй байна гээд Сангийн сайд болохоор бид нартай уулзаж байхдаа тайлбарласан юм л даа. Бид нар бүсчилсэн хөгжлөө ярина, жижиг сумын асуудал гэж хэдүүлээ ярихгүй шүү гээд. За гээд ойлгоод орсон.

Гэтэл сум дээр чинь түрээсэлье гээд ч цэцэрлэг байхгүй болчхоод байгаа

байхгүй юу. Тэгтэл бид нар сургууль, цэцэрлэг барьчих хэмжээнийхээ мөнгөнүүдийг хэд хуваагаад томилолтын зардал гээд үр ашиггүй гаргаад байна. Аудит хянах хянах ёстой юм уу? Сангийн яам өөрөө хяналт тавиад, хариулт хэлж байх ёстой юм уу? Энэ дээр хариулт байвал хэрэгтэй байгаа юм.

Дээрээс нь 2020 онд Баянхонгор аймгийн Баянговь сумд цэцэрлэг бариад ашиглалтад орсон. Шал нь 2 удаа цөмрөөд, хана нь хагаралт үүсээд тэнчээ чинь хүүхэд байх боломжгүй болчхоод байгаа байхгүй юу. Тэгэнгүүт Барилгын тухай хууль дээрээ нэмэлт, өөрчлөлт хийх гэж байна. Хэн хариуцлага хүлээх ёстой юм бэ гээд Төсвийн байнгын хороон дээр асуухаар Төсвийн байнгын хорооны дарга бол Барилгын хууль дээр тийм өөрчлөлт хийгдэж байгаа гэдэг тайлбарыг өгсөн. Энийг би үнэн, худлааг нь мэдэхгүй байна. Барилгын сайд энд байгаа юм бас хариулах боломж байвал.

Тэгээд барилгатай холбоотой дахиад нэг асуудал нь тарифт цалингийн нэмэгдлийн асуудлыг Сангийн сайд өнгөрсөн жилийн 3 сарын 28-нд салбарынхантай уулзаад Даваасүрэн сайд тэр үед сайд байсан, салбарынхантай уулзаж байхдаа 20 тэрбум төгрөгийг шийднэ гээд, тийм энэ оныхыг шийднэ гэсэн шийдэл нь байдаггүй гээд. Өнөөдөр дахиад гадаа жагсаал.../минут дуусав./

Д.Батбаяр: 1 минутаа авах уу? Нэмж 1 минут өгье.

Да.Цогтбаатар: Хаанаас нь байхгүй болчхов. Тэгээд энэ барилгын энэ төсөвт юу билээ? Барилгын салбарын ажилчдын тарифт цалингийн асуудлыг Сангийн сайд Барилгын яамны сайд Даваасүрэн сайд байхдаа энийг шийднэ гээд 20 тэрбум төгрөгийн асуудал оруулж байсан юм байна лээ. Тэгээд энэ 25 оны төсөв дээр байгаа эсэхийг бас тодруулах гэсэн юм.

Д.Батбаяр: Аудиттай холбоотой асуудлыг Загджав дарга хариулъя. 5 номерын микрофон.

Д.Загджав: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Төрийн аудитын байгууллага төрийн санхүү, төсвийг хараат бусаар хяналт тавьж ажилладаг.

Төсвийн тухай хуулийн 8.9 дүгээр зүйлд зааснаар санхүүгийн аудитыг жил бүр бүх шатны төсвийн захирагч нар хийж авдаг юм. Тэгэхээр та жоохон буруу ойлголттой байх шиг байна. Хуультай. Хариулж дууслаа.

Д.Батбаяр: Сангийн сайдад нэмж хариулах уу? Сангийн сайдын микрофоныг нээгээрэй.

Б.Жавхлан: Цогтбаатар гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье.

Ер нь шинэ Их Хурлын маань эхний төсөв, эхний том төсөв учраас бид аль болох л дэлгэрэнгүй мэдээллүүдийг өгөөд яваад байгаа гишүүддээ.

Тэгээд ингэсэн байгаа хавар Барилгын яам, манай яам хооронд энэ асуудал яг процессоороо явагдсан асуудал. Ер нь Барилгын тухай хуулиар барилгын зураг, төсөв хийхэд тэр нормативт цалингийн тарифыг барилгын чиглэлийн сайд, Сангийн сайд хамтарсан байдлаар баталдаг юм байгаа юм.

Ингээд энэ асуудал бас нэлээн хөндөгдсөн юм. КОВИД-ын үед ч нэлээн хөндөгдсөн. Ингээд 2 жил шахуу хуримтлагдаж байгаад өнгөрсөн өвлөөс энэ асуудлыг нэлээн судалгаатай үзэж аваад тэгээд 3 сар, таны саяын 3 сарын 28 гэж байна уу тээ? 3 сарын 28-нд уулзалт хийгдээд ингээд манай Сангийн яамнаас зөвшөөрөл өгөөд Барилга, хот байгуулалтын сайд тушаалаараа тарифт өөрчлөлт орсон юм. Орсон юм. 5 сарын 24-ний өдрийн тушаал байх

ёстой. Батлан хамгаалахын, юун Барилгын сайдын.

Ингээд энэнээс хойш яах ёстой вэ гэхээр энэ Барилгын хөгжлийн төв буюу Барилгын яамны дэргэд байдаг энэ институт шаардлагатай тэр магадлан өөрчлөлтүүдийг төслүүд дээр хийх ёстой. Ингээд яг магадлан хийгдсэн төслүүдийг барилгын Барилга, хот байгуулалтын яам нь өөрөө төсөвтөө энэ зөрүүн дээр тусгая гээд 9 сарын 1-нээс өмнө Сангийн яаман дээр ирүүлэх ёстой. 9 сарын энэ жил 9 сарын 1-нд төсөв өргөн барьдаг болчихсон учраас төсөв өргөн барихад энэ цалин тарифт шинэ тарифтай холбоотойгоор ч төсөл ирээгүй магадлан ирээгүй байхгүй юу.

Сая сураг сонсох нь ээ шинэ тарифт цалингаар магадлан яг бүрэн хийгдсэн ганцхан төсөл байгаа юм байна одоо. Ганцхан төсөл байгаа. Тийм, тэгэхээр бид хуулиа зөрчиж энд магадлан хийгдээгүй ийм хөтөлбөрүүдийг оруулж, төслүүдийг оруулж өргөн барьж болохгүй.

Тэгэхээр энд яах вэ төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо л бас харагдаж байгаа юм. Сайд нь тарифт цалинг нь өөрчлөлт орчихсон байж байхад 5 сараас хойш өнөөдрийг хүртэл зөвхөн цалингийн өөрчлөлт л орно шүү дээ. Ганцхан төсөл дээр хийгдсэн гэдэг аягүй хангалтгүй байгаа байхгүй юу. Тийм тэгэхээрээ хэрвээ 9 сарын 1-нээс өмнө хийгдчихсэн байсан энд эдгээр өөрчлөлтүүд ороод өргөн баригдаад одоо хэлэлцэгдээд явна л даа. Тийм. Энэ удаа ийм зүйл өргөн баригдаж амжаагүй байна.

Тэр яригдаж байгаа нэмж нийтлэг байдлаар дараа нь сайд нь өөрөө хуваарилах байдлаар нэмэлт оруулъя гэсэн бас тийм хувилбар санал Барилгын холбооноос яригдаж байна лээ. Тэрийг тэгээд хууль, дүрмийн хүрээнд Байнгын хороод, Зарлагын хяналтын дэд хороодод гишүүд санал гаргавал тэгээд хэлэлцээд

явна биз дээ. Тэр бол нээлттэй шүү дээ тийм ээ.

Д.Батбаяр: Батсуурь сайд хариулах уу? Сая танаас нэмж хариулах уу? Та тодруулга авах уу? Өө тийм, хяналтыг нь хийгээд, албан бичгүүдийг нь явуулаад эхний албан бичгүүд нь хугацаандаа ирээгүй байсан учраас өчигдөр завсарлага аваад, өглөө эрт уулзалтууд хийгээд, бичгээр нь хариултуудыг нь аваад ингээд явж байгаа. Тэгээд яг энэнтэй холбоотой энэ зарим асуудлууд нь тэнд манай нууцтай холбоотой улсууд тэнд сууж байх шиг байна. Тийм учраас дараа нь бичгээр нь энэ хариултуудыг нь аваад явчих боломжтой юм байна лээ.

Би бас өөрөө асуулт асууж болно тээ? Би их асуулт асууна. Нэлээн хэдэн асуулт асууна. Бүгдээрээ тэмдэглэж авч байгаад тэгээд дараа нь бас бичгээр бас өгчихнө биз. Хурдхан хурдхан хурдхан асууна хариулаад явчхаарай.

Нэгдүгээрт нь Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар. Нийгмийн даатгалын ерөнхий газар аудитын тайлан дээр 110 тэрбум төгрөгийн акт тавиулсан. Энэ асуудал дээр ямар хариуцлага тооцсон бэ? Энэ зөрчлийг арилгах талаар юу хийгдсэн бэ?

Эрүүл мэндийн даатгалын газар 250 тэрбум төгрөгийн зөрчил тавигдсан байгаа. Мөн адилхан зөрчлийг арилгах талаар ямар ажиллагаа хийгдсэн бэ? Ямар хариуцлага ноогдуулсан бэ? Хоёр даатгалын газартай холбоотойгоор бас энэ 3 банк байгаа. Энэ 3 банкин дээр тодорхой хэмжээний мөнгөн үлдэгдэл байдаг, хадгалагдаж байдаг гэдэг. Энэ дээр апдэйт/update/ өгөөд хэдэн төгрөгийг нь буцааж авсан бэ гэдэг дээр нэмэлт мэдээлэл өгчхөөрэй.

Гуравдугаар асуулт, “Эрдэнэс Тавантолгой” байгаа билүү? “Эрдэнэс Тавантолгой” байгаа тээ? Энэ нүүрс угаах үйлдвэртэй очиж танилцсан. Энэ

үйлдвэр бол зогсолтын, үйлдвэр дууссан боловчиг зогссон байдалтай байна. Тэгэхээр энэний санхүүжилт хаанаас хийгдсэн юм бэ? Энэнтэй холбоотойгоор энэ ямар шалтгаанаар байсан бэ гэсэн чинь нэгдүгээрт усны эх үүсвэр байхгүй, хоёрдугаарт нь цахилгааны эрчим хүчний нэмэлт ажил хийгдэх шаардлагатай гэсэн байгаад байгаа. Тэгээд энэ ТЭЗҮ-д нь орсон байсан юм уу? Энэ усны асуудлыг нь яаж шийдэх гэж байна вэ? Энэ төсөвт суугдаагүй байсан. Тэгэхээр одоо өөрийнхөө хөрөнгөөр хийгдэх боломжтой болж таарч байх шиг байна. Энийг хийх боломжтой байгаа юу? Хэдэн жилийн хугацаанд хийх вэ? Хэзээ ер нь энэ үйлдвэр ашиглалтад орох вэ, ажиллаж эхлэх вэ?

Дарханы төмөрлөгийн үйлдвэр байна уу? Дарханы төмөрлөгийн үйлдвэр 2023 онд та бүхэн ойролцоогоор 2.5 тэрбум төгрөгийн урамшуулал ажилчдадаа тараасан байгаа. Та бүхэн бол нийт үйл ажиллагааныхаа яг үйлдвэр бол 30 орчим хувийг ашигласан байгаа. Тэгэхээр ямар үндэслэлээр та бүхэн маань энэ урамшууллыг тараасан бэ? Нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаарт нь хэдэн төгрөгийн өглөг хаана байгаа вэ танайд?

Гуравдугаарт нь биржээр ер нь яагаад та хэд минь ахиад бүтээгдэхүүнээ зарахаа больчихов? Та бүхэн минь биржээр зарсан хүргээгүй байгаа худалдан авагчдаа өгөөгүй байгаа хэдэн тонн бүтээгдэхүүн байна вэ?

Дөрөвдүгээрт нь дөрөвдүгээрхийг нь би энэ Сангийн сайдаас асуучихъя гэж бодож байна. Энэ Дарханы төмөрлөгийн үйлдвэр дээр бага агуулгатай хүдэр их хэмжээгээр хадгалагдаж байгаа юм байна. Тэгээд энийг энэ Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг тойрсон, Дархан-Уул аймгийг тойрсон хайлах цех үйлдвэрүүд байдаг юм байна. Тэгэхээр ажлын байрыг ч нэмээд, хувийн бизнесийнхнээ ч дэмжээд энэ бага агуулгатай хүдрийг ер нь борлуулчхаж

болдоггүй юм уу? Заавал биржээр гэхээр биржийн хувилбараа хуулиа солих болчихоод байгаа өөрчлөх хэрэгтэй болчихоод байгаа ухаас Сангийн сайдын тушаалаар энэ борлуулалтыг хийхээ байсан гэсэн мэдээлэл байгаад байгаа.

Тэгэхээр та энэ дээр тодруулга өгнө үү.

Дөрөвдүгээрт нь Эдийн засаг, хөгжлийн яам Батхүү дарга байх шиг байна тээ? Иргэдээс мэдээлэл ирсэн. Тэгэхээр энэ татварын орчныг сайжруулах зорилгоор энэ Германы хамтын үйл ажиллагааны корпорац Жи Ай Зэ-гийн 1.5 сая еврогийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр болсон юм байна. Санхүүгийн асуудал нь шийдэгдчихсэн ороод ирчихсэн байгаа юм байна. Энийг хэнтэй хамтарч, ямар байгууллагатай хамтарч хэрэгжүүлэхээр анх тохирсон байсан юм бэ? Одоо ямар шатандаа явж байгаа юм бэ гэдэг дээр хариулт авчихъя.

Боловсролын яамныхан байна уу? Боловсролын яамныханд бас ажлын хэсгийнхэн хүргэгчээрэй асуултыг нь. Энэ шилжисж орж ирж байгаа энэ оны 25 оны багц дээр 190 орчим барилга байгууламж шинээр баригдахаар үргэлжлүүлж баригдахаар орж ирж байгаа юм байна. Тэгэхээр хэдэн сургууль, цэцэрлэг ашиглалтад орох вэ Наранбаатар, Наранбаяр сайд аа 2025 онд? Нийтдээ хэдэн ажлын байр бий болох вэ, урсгал зардал нь хэр нэмэгдэх вэ, хөрөнгийн зардал нь хэр нэмэгдэх вэ гэдэгт хариулт авмаар байна. Хүний нөөцийнхөө асуудлыг шийдэж байна уу? Энэ олон багш нар, ажилчдынхаа асуудлыг шийдэж байгаа бодлого байна уу гэж асуумаар байна.

Хоёрдугаар асуудал нь юу вэ гэхээр энэ Орхон аймгийн Баян-Өндөр сумын Рашаант багт баригдаж байгаа 250 хүүхдийн сургуулийн барилга 4 дахин өсчихсөн байгаа юм. 4 тэрбум орчим болоод өсчихсөн юм байна. Энэ дээр магадлан гээд байгаа шинэчилсэн магадлан билүү сайд аа? Тийм

шинэчилсэн магадлан гэдэг юм хийгдсэн үү? Энэ ямар үндэслэлээр энэ өссөн бэ? Мөн Баянхонгор аймгийн Баянцагаан суманд бас 320 хүүхдийн сургууль 9.1 тэрбум, 9.5 тэрбум буюу анхны төсөвт өртгөөсөө 2.8 дахин өсчихсөн байгаад байгаа юм. Энэ бас ямар үндэслэлээр өссөн бэ? Нөгөө шинэчилсэн магадлан нь хийгдсэн үү гэдэг асуулт байна.

Аудитын байгууллагаас бас асуулт байна. Сүүлийн асуулт энэ 2025 онд чинь орон тооны дээд хязгаар нь өөрчлөгдөж байгаа юм байна. Нэмэгдэж орж ирж байгаа юм байна. Цалингийн сан нь нэмэгдэж өөрчлөгдөж орж ирж байгаа юм байна. Тэгэхээр үйл ажиллагааных нь хүрээ нь өөрчлөгдөж байгаа юм уу? Ямар үндэслэлээр орон тоо ингэж нэмэгдэж орж ирж байгаа вэ? Цалингийн зардал хэр их өсөх вэ гэсэн ийм асуултууд байна. Бүгдээрээ эхнээс нь хариулаад явчихъя.

Эхлээд Ганцэцэг даргын микрофоныг нээчихье. Айн? 1 номерын микрофоныг, 1 номерын сандлыг чөлөөлөөд тэн дээрээ суугаад хариулаад хариулаад явчихъя.

Ц.Ганцэцэг: Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ганцэцэг байна. Батбаяр гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газраас гаргасан зөрчил алдаатай холбоотой, энэ алдааны юуг тайланг бид нар үндсэндээ гаргаад цахим хэлбэр Үндэсний аудитын газар 9 сарын 30-ны өдөр өгсөн. Үндсэндээ манайтай холбоотой асуудал бол 2 банканд мөнгө байршуулсантай холбоотой ийм тоон мэдээлэл байгаа.

Капитал банк, Чингис хаан банкттай холбоотой мэдээлэл өгье. Анхны авлага бол Капитал банк 104.2 тэрбум төгрөг байсан. Энэ авлагаас өнөөдөр өчигдрийн байдлаар 65.9 тэрбум төгрөгийн авлагатай бид нар байна. Үндсэндээ барагдсан авлагыг нь аваад үзэхээр хөрөнгөөр болон мөнгөөр 38.3

тэрбум төгрөгийн шимтгэлийн өр төлбөр барагдсан.

Чингис хаан банктэй холбоотой мөн зөрчилд тооцогдсон 103.6 тэрбум төгрөгийн анхны өр төлбөрийн авлага байгаа. Өнөөдрийн байдлаар 95.4 тэрбум төгрөгийн авлагатай байна.

Өнгөрсөн хугацаанд Чингис хаан банкнаас 8.2 тэрбум төгрөгийг үндсэндээ төлсөн. 2 банкны хувьд нийт дүнгээрээ 161.3 тэрбум төгрөгийн шимтгэлийн өр, авлага байна.

Д.Батбаяр: Эхлээд бүгдээрээ хариулаад хариулаад явчихъя. Дараа нь би модруулж асууя тээ. Одоо Эрүүл мэндийн даатгалын газрын төлөөлөл.

М.Нармандах: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч Нармандах.

Капитал болон Чингис хаан банктэй холбоотой 108 тэрбум төгрөгийн авлагын асуудал Эрүүл мэндийн даатгалын сан дээр байгаа. Анх бол Чингис хаан банк дээр 27.8 тэрбум төгрөгийн авлага байсан, 3 шатны шүүхээр яваад 3 тэрбум төгрөгийн хүү тооцогдоод нийтдээ 30.8 тэрбум төгрөгийн авлагатай байгаа. Үүнээс энэ жил 200 сая төгрөг орж ирсэн нийтдээ. Капитал, Чингис хаан банк дээр 30.6 тэрбум төгрөгийн авлагатай байна.

Капитал банкны хувьд бол анх 136.1 тэрбум төгрөгийн авлага байсан. Үүнээс 12 тэрбум төгрөгийг бэлэн мөнгөөр, 46 тэрбум төгрөгийн объектыг Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөрт авсан. Одоогийн үлдэгдэл бол 77.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа.

Аудитын байгууллагаас манай байгууллагад 218 тэрбум төгрөгийн өглөгтэй байна гэж албан шаардлага өгсөн. Энэхүү 218 тэрбум төгрөгийн өглөгийг 7 дугаар сарын 31-ний өдрийн

байдлаар 68.3 хувийг нь барагдуулаад явчихсан дүнтэй байгаа. Баярлалаа.

Д.Батбаяр: Спорт, соёл, аялал жуулчлалын яам байна уу? Ажлын хэсгийнхэн асуултаа дараа нь хүргүүлээд хариултаа авчхаарай. Та байгаа юм уу? Та хариулах уу тээ? Тийм. Наана чинь Спортын яам яамтай холбоотой асуудал байгаад байгаа шүү дээ тээ. Соёл, спортын. Ингэчихье дээ Соёл, спортын аж үйлдвэрийн яамныхыг больчихъё. Аялал жуулчлал яамныхыг. Тийм бичгээр авчихъя. Энэ дээр ингэсэн байгаа. Тийм энэ Төв халх, Боржигон гээд 2 яам байгаад, юу 2 театр байгаад байгаа байхгүй юу.

Тэгээд энэ ямар учиртай 1 яаманд яагаад 2 ийм театр байгаад байдаг юм бол? Нэг нь 3.5 тэрбумаас 1.4 тэрбум болоод өсчихсөн. Нөгөөх нь бүр гацчихсан ийм яам яамнууд байгаа, театрууд байгаад байгаа. Энэ ямар учиртай юм бэ? Байж байгаарай даргаа, тэгээд бас соёлын төвийн асуудал байгаа даа даргаа, энэ нөгөө Төв аймгийн Рэнчинлхүмбэ сумын соёлын төв 1.4 тэрбум байж байснаа 4.6 тэрбум болчихсон. Тэгээд нөгөө таны түрүүний хэлээд байдаг нөгөө шинэчилсэн магадлал энэ тэр нь хийгдсэн юм уу? Тайлан нь, гүйцэтгэлийн тайлан нь хийгдэж байж ингэж орж ирж байна уу энэ дээр гээд ийм юм байгаад байгаа юм.

8 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Сангийн яам, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал. Таны асуултад хариулъя.

Төв халхын театр болохоор Дундговь аймгийн Сайнцагаан суманд 2010 онд эхэлсэн. Өнгөрсөн жил ер нь бол энэ төслийн хувьд анх эхэлсэн өртөг нь 2 тэрбумаар эхлээд, дунд нь төсөвт өртөг магадлалууд хийгдээд одоогоор Соёлын яаман дээр шүүхийн маргаантай 2010 онд эхэлсэн. Боржигон театр болохоор

Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд эхэлсэн. 2 өөр аймагт.

Түрүүний боловсрол дээр байгаа сургуулиудын хувьд болохлоор Баянхонгор аймгийн Баянцагаан сумын сургууль 2019 онд эхэлсэн. Анх болохоор 3.4 тэрбумаар эхлээд 2023 онд барилгын материалын үнийн өсөлтөөр материалын үнийн зөрүү болж нэмэгдээд 5.3 тэрбум болсон.

2024 оны төсөв дээр аудитын дүгнэлтээр бас төсөвт өртгийн нэмэгдэл болоод 9.5 болсон, магадлан нь хийгдсэн. 25 он дээр төсөвт өртгийн өөрчлөлт байхгүй. Яг энэ нэмэгдсэн төслийн өртгийнх нь үлдэгдэл санхүүжилт тусгагдаад явж байгаа.

Орхоны Баян-Өндөрийн сургууль Рашаант багийнх мөн 250 суудалтай. 2018 онд анх 1 тэрбумаар эхэлсэн. Мөн яг энэнтэй адилхан өртөг нь нэмэгдээд өнгөрсөн жил аудитын дүгнэлтээр 3.9 тэрбум болсон 25 оны төсвийн төсөл дээр өртгийн өөрчлөлт байхгүй. 3.9-ийн нэмэгдлийнх нь зөрүү тавигдаад явж байгаа.

Д.Батбаяр: Боловсролын яамны 2025 онд хэдэн сургууль, цэцэрлэг ашиглалтад орох вэ гээд асуусан асуулт байгаа тээ? Ахиад бичгээр явуулж таарч байна. Төлөөлөл нь байхгүй байгаа юм уу? Наранбаяр сайд байхгүй байгаа юм уу? 8 номерын микрофоныг нээе.

Ж.Дэлгэржаргал: 2025, 2025 оны төсвийн төсөл дээр 90 сургууль байгаа. 90 сургуулийн 65 сургууль нь 25 онд ашиглалтад орно. Үлдсэн нь 26 онд байгаа. Хамгийн яг төсвийн төсөл дээр байгаа 90 сургууль, 62 цэцэрлэг, 22 дотуур байр, 31 эмнэлгийн хувьд бол бүгд ер нь 23, 24 онд эхэлсэн. Хуулийн хугацаагаараа хамгийн цаад талын хугацаа 26 онд дуусна. 90 сургуулийн 65 сургууль нь 25 онд ашиглалтад орно.

Д.Батбаяр: Одоо чинь юу байгаа билээ? Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Д.Батбаяр: 2 номерын микрофоныг нээе.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Батбаяр гишүүний асуултад хариулъя.

Монгол улс ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хөгжлийн хамтын ажиллагааны хэлэлцээр 92 оны техникийн тусалцааны тухай хэлэлцээр байгуулагдсанаас хойш 2 жил тутам зохион байгуулж ирсэн. 2020 онд, 22 онд Монгол Улсын 1 хүнд ноогдох орлогын хэмжээ өссөн гэдэг шалтгаанаар түр зогсоосон байснаа бас 2 талын яриа хэлэлцээрийн дүнд буцааж сэргээсэн байгаа. Энэ удаагийн ээлжит хэлэлцээр нь 25 оны 3 сард болох юм. Энэ 3 сард болох хэлэлцээний өмнө холбогдох яам, бусад төсвийн ерөнхийлөн захирагчдаас 2 улсын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх шинэ төслүүдийн саналыг хүлээж аваад Эдийн засаг, хөгжлийн яам Германы талтай урьдчилсан байдлаар тохиролцож ажиллана.

Таны асуусан татварын орчныг сайжруулахтай холбоотой техник тусалцааны санал 23 онд Сангийн яамнаас тухайн үед Германы талд хүргэгдсэн байгаа. Хэрэгжүүлэгч байгууллага нь Сангийн яам гэсэн төслийн санал дээр тусгагдсан байгаа. Энэ төсөл болон бусад шинээр хэрэгжүүлэх төслүүдийн асуудлыг Германы талтай ойр хэлэлцээд явуулж шийдвэрлэнэ гэж.

Д.Батбаяр: Аудитын байгууллагын та хариулах уу? 5 номерын микрофоныг нээе.

Д.Загджав: Батбаяр даргын асуултад хариулъя. Төрийн аудитын байгууллага нийт Төв, Үндэсний аудитын газраас гадна 21 аймаг, Нийслэлд аудитын байгууллагууд ажиллаж байна. Энд жилд санхүүгийн 5442 аудит, 2440 гаруй гүйцэтгэл-нийцлийн аудит хийж

байгаа юм. Аудитын бас олон улсын стандарт гэж юм байна. Тэгэхээр энэнээсээ манайх орон тооны хувьд, хүн хүчний хувьд, техник тоног төхөөрөмжөөс хэд дахин доогуур явж байгаа юм. Тэгээд өнгөрсөн онд манай аудитын орон тоог бас 99 орон тоогоо нэмэгдүүлэхээр бид бас 150-аад орон тоо хүссэн. Тэгээд нийт тоогоороо ярих юм бол бас нэлээн их байх ёстой.

Гэхдээ бид нар өнөөдөр энэ 99 орон тоогоо нэмэгдүүлэхээр үе шаттайгаар нэмэгдүүлэхээр ирэх оны төсөвт 5 орчим тэрбум төгрөг шаардлагатай байгаа. Хариулж дууслаа. Баярлалаа.

Д.Батбаяр: Би 1 минутынхаа би тодруулгаа авчихъя.

Саяын Эрүүл мэндийн даатгал, Нийгмийн даатгалын газрууд банканд мөнгө байршуулсан талаар хариулт та өгчихлөө. Ер нь энэ аудитын байгууллагын дүгнэлттэй холбоотойгоор хариуцлага энэ тэр яригдсан уу? Зөвхөн банканд хадгалуулсан мөнгөнөөсөө гадна мөн нягтлан бодох бүртгэлийн болон бусад асуудлууд дээр зөрчил гараад тэн дээр акт тавигдсан байгаад байгаа шүү дээ. Энэ дээрээ та бүхэн минь ямар ажил хийсэн бэ? Шинэ төсөв батлагдахаас өмнө хуучин ажлаа ярьчихмаар байна. Та 1 номерын микрофон дээр ирээд та 2.

М.Нармандах: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар Нармандах.

Эрүүл мэндийн даатгалын сан дээр акт тавигдаагүй. 4 албан шаардлага, 1 зөвлөмж ирүүлсэн байгаа. 250 тэрбум төгрөгийн зөрчил бол 218 тэрбум төгрөг дээр нь өг, бусдад, бусад байгууллагуудад өгөх өглөгийн асуудал нь дараа жилийн төсөвт нөлөөлөхөөр байна гэдэг утгаараа албан шаардлага өгсөн байгаа. Нөгөө 30.8 тэрбумын асуудлууд Чингис хаан банктэй холбоотой 3 шатны шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг

нь хангахтай холбогдсон албан шаардлага байгаа.

Д.Батбаяр: Та байж байгаарай. Би ахиад нэг юм асуучихъя. Одоо таны энэ нөгөө тайлангийн чинь энэчээ дүгнэлт нь хэсэгт нь байна л даа. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 250 тэрбум 430 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшинээс өндөр санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг бүрэн үүрэг, иж бүрэн тохиолдсон байх, нийцтэй байх, зохистой байх, батламж мэдүүлгүүдийг хангахгүй байна гэж байгаа юм.

Тэгэхээр чинь энэ танай энэ байгууллага чинь хуульд нийцүүлж ажиллаж чадахгүй байгаад байгаа юм биш үү? Энэ дээрээ гол нь ямар арга хэмжээ авсан юм бэ л гэж би асуугаад байгаа байхгүй юу.

М.Нармандах: Албан шаардлагын хувьд хамгийн их тоо буюу 218.3 тэрбум төгрөгийг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад төлөх нийт 2350 байгууллагын 218.3 тэрбум төгрөгийн өглөгийг 1 дүгээр улиралд Сангийн төсвийн бодлого төлөвлөлтийн газарт төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж, өр төлбөрийг 68.5 хувиар биелүүлэхтэй холбогдсон асуудал байгаа. Тэгээд бид нар бол 68.8 хувиар албан шаардлагын биелэлтийг хангаад хүргүүлчихсэн. Өглөгийн асуудал байгаа гишүүнээ.

Д.Батбаяр: Нийгмийн даатгалын.

Ц.Ганцэцэг: Нийгмийн даатгалын ерөнхий газар нэмэлтээр хариулт өгье. Энэ Үндэсний аудитын газрын зөвлөмж, шаардлагын дагуу нийтдээ салбарын хэмжээнд 110 тэрбум төгрөг байгаа. Энэнээс 96.4 тэрбум нь үндсэндээ Чингис хаан банктэй холбоотой төлбөр тооц. зөрчил. Энэ чиглэлээр бид нар Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлдөө үндсэндээ асуудал тавьсан, танилцуулсан.

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлөөс тодорхой чиглэл өгсний дагуу Ерөнхий газраас Улсын Ерөнхий прокурорт бас хандаж энэ гэм буруутай этгээдийг тогтоох ийм гомдлыг бол гаргасан байгаа. Энэ гомдлын дагуу прокурорын газраас Авлигатай тэмцэх газарт бас энэ чиглэлээр мэдээллийг шилжүүлсэн гэсэн дүнг бид нарт ирүүлсэн.

Энэ 2025 оны төсвийн хувьд бас энэ 2 банкны өр төлбөрийг барагдуулахтай холбоотой нийгмийн даатгалын байгууллагын хувьд бас захиргааны байгууллага учраас хуулийг энэ өр төлбөрийг барагдуулах ийм аж ахуйн ажил хийхэд бас хүндрэлтэй байгаа.

Тийм учраас мэргэжлийн, хуулийн фирмүүдийг бас ажиллуулъя, мэргэжлийн өмгөөлөгчтэй хамтарч ажиллая гэсэн чиглэлээр манай сайдаас бас зарчмын зөрүүтэй саналыг 2025 оны төсвийн төсөл дээр өгөөд ингээд явж байгаа гэж ингэж харж байгаа. Нэмэлтээр үйл ажиллагааны зардал дээр тодорхой хэмжээний үйл ажиллагааны зардал тусгуулах, хуулийн фирмүүдтэй хамтарч ажиллах, өр төлбөрийг барагдуулах чиглэлээр ажиллана гэсэн байдлаар төлөвлөсөн байгаа.

Д.Батбаяр: Та түрүүн асууж байсан тээ? Хэнээс асуусан билээ та? Аудитаас асуусан. Тэгээд тодруулгаа, танд хуулиар яг энэ дэгийн тухай хуулиар 1 минутын эрх байгаад байгаа тийм үү? Тэр Дэгээр тодруулгаа авчих. Цогтбаатар гишүүний микрофоныг нээчихье.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Загджав даргаа манай энэ дарга нарт энэ асуудал худлаа мэдээлэл доороос нь ирээд байгаа байхгүй юу. 10 сарын 25-нд Архангай аймгийн Аудитын газраас надад ирүүлсэн албан бичиг нь энэ байна. Сүүлийн 4 жил Засаг даргын Тамгын газар Санхүү, бүртгэлийн газарт аудит хийгээгүй ээ, Байгальмаа гэсэн даргын гарын үсэгтэй. Аудит хийгдээгүй.

Тэгээд ерөөсөө хэн ч хариуцлага хүлээдэггүй, хэн ч хянадаггүй ийм тогтолцоо руу төр орчихсон. Тэгээд 33.8 их наяд хэдэн 100 тэрбумаар нь үрнэ л гээд тэгээд хууль яриад байх юм. Үр дүнтэй баймаар байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь хариуцлага энэ чинь Зарлагын хяналтын дэд хороо байж зарлагынхаа талаар үр дүнг нь ярьж гэхээр дэг дээр тийм юм алга гээд хаана ярих юм. Улсын Их Хурлын чуулган дээр бас байхгүй. Аудит ингэж болохгүй шүү дээ. Аудит худлаа яриад байна, эсвэл танай Архангайн аудит надад худлаа яриад байна, эсвэл та наанаа суучаад надад худлаа яриад байна. Намайг доромжилж.../минут дуусав./

Д.Батбаяр: 4 номерын микрофон.

Ц.Наранчимэг: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

Сая Монгол Улсын Ерөнхий аудитор хариултдаа хэлсэн. Нийт 5442 төсөвт байгууллагад Төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.8-д заасны дагуу санхүүгийн тайлангийн аудит хийж, дүгнэлт өгч байгаа.

Таны ирүүлсэн бичиг бол Төрийн сангийн хэлтэст аудит хийсэн үү гэсэн ийм бичиг байсан. Төрийн сан өөрөө Засаг даргынхаа Тамгын газарт харьяалагдаж явдаг, бие даасан төсөв захирагч биш, харилцагч төсвийн байгууллагууддаа санхүүжилт олгодог ийм байгууллага учраас энд хуулиараа тусгайлсан дүгнэлт гаргадаггүй.

Харин 2019 онд бид Монгол Улсын төрийн сангийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж болдог. Санхүүгийн тайлангийн дүгнэлт өгөх аудитыг хийх хууль, эрх зүйн орчин байхгүй байгаа учраас Архангай аймаг хийгээгүй. Архангай аймаг бол Засаг даргын Тамгын газартаа төсвийн шууд захирах гэж байгаа Тамгын газрын дарга нь, Тамгын

газартаа жил болгон аудит хийж, дүгнэлт гаргаад явдаг. Манай audit.mn сайт дээр Архангай аймгийн Тамгын газарт гаргасан аудитын дүгнэлт, тайлангууд байж байгаа.

Д.Батбаяр: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Өө тийм шүү дээ. Та танаас асуусан шүү дээ тээ? Тийм, уучлаарай. Жавхлан сайдын.

Б.Жавхлан: Батбаяр даргын асуултад хариулъя. Тэр Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн бага агуулгатай төмрийн хүдрийг экспортлохыг зогсоосон гээд тэглээ та. Ер нь бол зогсоосон гэж бас буруу ойлгож болохгүй шүү. Хавар бол тодорхой асуудал гарсан, тодорхой нэг кэйс гарсан. Энэ дээр бас нэлээн тийм сургамж авахаар байна. Энэ биржээр уул уурхайн бүтээгдэхүүнүүдийг явуулж байгаа зүйл чинь манай улсад бас шинэлэг.

Төрийн болон төрийн өмчийн оролцоотой, 1 хувийн ч оролцоотой байсан гэсэн тухайн уул уурхайн компани биржээр 1гр ч байсан бүгдийг нь явуулах учиртай юм байгаа юм. Энд биржээр явуулахгүй байх тийм юу гэдэг юм бэ дээ, хонгил үүсчхээд байна гэх үү дээ. Бага агуулгатайгаа экспортлох зорилгоор биш дотоодын аж ахуйн нэгжид зарчихаар заавал биржээр явуулах шаардлагагүй ийм тохиолдолд нь хуулиар нээлттэй болчихоод, бага агуулгатайг жишээ нь, 30 агуулгатайг дотоодоороо зүгээр зараад, нөгөөдөх нь очоод сэгсрээд л шороог нь шорооноос нь 32 хувийн агуулгатай жоохон баяжуулаад л тэгээд л шууд экспортлох. Тэгээд тиймэрхүү асуудлууд үүсээд байгаа юм. Зэс дээр ч тэр. Ер нь ганц Дарханы төмөрлөг дээр биш, нийтлэг ийм асуудал үүсчхээд байгаа юм.

Тийм учраас энийг зүгээр цаашидаа тэгэхээр тушаал энэ тэр гаргаж зогсоосон зүйл ерөөсөө байхгүй шүү. Тэр буруу мэдээлэл очсон байна. Энэ одооё Эрдэс баялаг, уул уурхайн сайдын саналаар Засгийн газар дээр биржээр

явуулах бүтээгдэхүүний жагсаалтыг баталдаг юм байгаа юм. Тэгэхээр Сангийн сайд энд огт оролцохгүй.

Бид нар ямар санал хүргүүлж байсан бэ гэхээр иймэрхүү цоорхой үүсээд байгаа учраас тэр дотоодын худалдаа, арилжаагаа ч гэсэн биржээр явуул, эсвэл баяжуулсан, дотооддоо худалдаад баяжуулсан байх, эсвэл хэрэглэсэн байх тэр стандарт босгыг нь тавьж өг. Хэрвээ 30 хувийн хүүтэй, бага агуулгатай дотооддоо зар, дотоодын аж ахуйн нэгжид баяжуулдаг аж ахуйн нэгжүүд зараад, цаадхаа баяжуулаад экспортолсон бол бүтээгдэхүүн бүр дээр нь тэр баяжуулалтынхаа доод босгыг нь тавьж өг. Тэгэхгүй бол ерөөсөө нэг, хоёрхон хувиар баяжуулчихаад л экспортолсон. Нөгөө туг тойруулж байгаа юм шиг л ийм л юм цоорхой үүсчхээд байгаа байхгүй юу. Тийм учраас бид санал хүргүүлж байсан л юм байгаа юм.

Тэрнээс бол Сангийн сайдын тушаалаар тэрийг зогсооно гэж байхгүй л дээ. Тодорхой кэйс гараад, гаалийн дарга Сангийн сайдаас манай дээр ийм юм болчихлоо энэ чинь ерөөсөө 2-хон хувийн баяжуулалттай мөртөө биржээр явалгүй дотоодын аж ахуйн экспортолно гээд хүрээд ирлээ. Энийг яах вэ гээд биднээс асуусан юм.

Тэгэхээр нь тэр дээр бид нарт ийм санал өгөөд, ер нь наадах чинь болохгүй шүү. Уул уурхайн яам, Эдийн засаг, хөгжлийн яамд тэр бид нар бас давхар ийм санал хүргүүлээ. Энийг баяжуулахынхаа доод талын тэр хязгаарыг нь зааж өг, эсвэл дотоодынх ч байсан гэсэн биржээр явуул гэдэг л ийм санал хүргүүлсэн байгаа.

Д.Батбаяр: Жавхлан сайдад баярлалаа. Энэ асуулт, хариулт дуусаагүй явж байна. Төмөрлөгийн үйлдвэрийн төлөөлөл ирчихсэн тээ? Та 1 номерын микрофон дээр босоод хүрээд ирэх үү. 1 номерын микрофоныг.

Г.Бадрах: Баярлалаа. Батбаяр гишүүний асуултад хариулъя.

2023 онд манай компанийн татварын дараах ашгаар 40.1 тэрбумын ашигтай гарсан байгаа. Дарханы төмөрлөгийн үйлдвэр нь үйлдвэрчний эвлэлтэй хамтын гэрээ байгуулдаг. Хамтын гэрээний дагуу 13 дахь сарыг ашгийн 1 сарын цалинг олгоно гэсэн заалтын дагуу урамшуулалтыг олгосон байгаа.

Биржсийн худалдаатай холбоотой асуудал ер нь өнөөдрийн байдлаар Дарханы төмөрлөгийн үйлдвэр сая 70 мянган тонн экспортын баяжмалыг зараад 100 хувь мөнгөн төлбөрийг авсан байгаа. Энэ авсан байгаа. Тэрэнтэй холбоотойгоор тээвэрлэлтийн асуудал, тээвэрлэлт, ложистикийн хүндрэлийн улмаас өнөөдрийн байдлаар 970 мянган тонн төмрийн хүдрийн баяжмалыг экспортолж чадаагүй байдалтай байгаа. Үүнээс үүдэн Монголын хөрөнгийн биржээс 930 мянган тонн ачааг тээвэрлэж, тээвэрээс ... нөхцөлөөр ... нөхцөлд хүргэсэн нөхцөлд дуудлага худалдааг явуулна гэсэн байр суурийг илэрхийлж байгаа.

Мөн тэгээд тээвэр, ложистикийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэгдээд явж байгаа. 2024 оны 2 дугаар хагасын байдлаар экспортын баяжмалын тоо хэмжээ 170 мянган тонныг экспортолчихсон байгаа. 24 оны, 24 оны эхний хагасын байдлаар 95 мянган тонн Биржсийн экспортын баяжмалыг явуулсан байгаа.

Тийм. Би сая нөгөө цэвэр ашгийн, цэвэр ашгаас 13 дахь сарын цалинг олгосон байгаа. Хамтын гэрээний дагуу үйлдвэрчний эвлэлийн. Өр төлбөрийн асуудал дээр өнөөдрийн байдлаар Дарханы төмөрлөгийн үйлдвэр 839 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байгаа. Авлагын хувьд 600 тэрбум төгрөгийн авлагатай байгаа.

Д.Батбаяр: Бүх асуултаа асууж дууслаа гишүүд маань. Хариултаа бас авсан гэж үзье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.5 дахь хэсэгт бусад Байнгын хороо Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд гишүүн, нам, эвслийн бүлэг, төрийн аудитын төв байгууллага саналаа зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт гаргана гэж.

Мөн хуулийн 39.14 дэх хэсэгт гишүүн зарчмын зөрүүтэй саналаа хэлэлцүүлэг явуулахаас өмнө ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө бичгээр урьдчилан ирүүлэхээр заасан гэж байна. 2-оос доошгүй өдрийн өмнө ирсэн хэдэн санал байгаа юм? Энэ хугацаанд 4 санал ирсэн юм байна. Тэгээд тус бүрд нь яах ёстой юу? Тус бүрд нь санал хураагаад, гишүүд маань саналаа өгөх нь. Би унших юм уу тээ?

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зохицуулалт хийх санал гэнэ.

Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.178.Цэцэрлэгийн барилга Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумд 200 ортой цэцэрлэгийн барилга, хэрэгжих хугацаа 2019-2025 он, төсөвт өртөг 2 тэрбум 100 сая төгрөг, санхүүжих дүн 1 тэрбум 500 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 717.9 сая төгрөгөөр бууруулж, XVI.1.1.31 Баруун-Урт, Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам 61.9км 24 аравны, 24 метртэй гүүр Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум гэнэ. Хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг нь 11 тэрбум 121 сая 700 гэж байна уу тээ? 11 тэрбум 121 сая 700, 121.7 сая төгрөг, энэ нь санхүүжих дүн нь 5 тэрбум 548.3 сая төгрөг гэсэн төсөл хэмжээний нэрийг 24, энэ чинь юу билээ? 24 урт метр гэсний дараа гэрэлтүүлэг гэж нэмж, төсөв өртөг болон санхүүжих дүнг 717.9 сая төгрөгөөр нэмэх гэж байна.

Нэгнээс нь бууруулаад, нөгөөдхөд нь нэмж байгаа гэрэлтүүлэг гэдэг байдлаар нэмж байгаа юм байна. Энэ дээр санал хураая. Төхөөрөмжөөр хураах ёстой тээ? Төхөөрөмж дээр хураагдах ёстой, гишүүд бүгдээрээ төхөөрөмж дээр саналаа өгөх ёстой биз дээ? Манай ажлын албаныхан санал хураахаас өмнө та тайлбарламаар байгаа юм уу? Тэгвэл Батсуурь гишүүний микрофоныг нээчихье.

Ж.Батсуурь: Төсвийн зарлагын хорооны гишүүддээ оройн мэнд хүргэе. Төсөв дотроо эх үүсвэрийн зохицуулалт хийж байгаа юм. Баяндэлгэр сум манай Эрдэнэцагаан сум хоёр 18, 19 онд эхлээд, зарцаад, гэрээ нь цуцлагдчихсан. Тэгээд энэ дээр 2.1, 2.160 гэсэн мөнгө 25 он дээр тавигдаад ороод ирсэн.

Тэгэхлээр энэ нэгэнт хэрэггүйгээр намар татагдчих учраас энэ эх үүсвэрээ үргэлжилж явж байгаа. Сүхбаатар сум чиглэлийн замын төсөв дээр нь нэмэгдүүлэх, нөгөөдөх нь аудитын барилгын юун дээр нэмэгдүүлэх ийм дотор, өөрийнхөө дотроо төсвийнхөө эх үүсвэрийг зохицуулалт хийж байгаа юм. Шинэ ажил биш үргэлжилж байгаа ажил дээр тавигдаж байгаа учраас Төсвийн байнгын хорооны гишүүд та бүхнийг дэмжиж өгнө үү гэж уриалж байна, Булгаа гишүүн ээ.

Д.Батбаяр: Саяын миний уншсан энэ санал дээр санал хураалгая.

Тийм энэ миний төхөөрөмж болсонгүй. Тэгэхээр энийг протоколд, айн? Миний төхөөрөмж ажиллаагүй учраас дахиад саяын саналыг саяын унасан саналыг хүчингүй болгох дээр ахиад санал хураачихъя.

Өө будилуулчих юм аа. Дахиад явчихсан уу? Тийм, ахиад болохгүй байгаад байна. Миний энэ төхөөрөмж ажиллахгүй байгаад байна л даа. Тэгэхээр энийг яах юм айн? Саналыг хүчингүй болгох санал маань уналаа.

Одоо 2 дахь дээр нь. Үгүй шүү дээ сая тэрийг нь ахиад хураалгачихлаа шүү дээ сайд аа. Саналыг хүчингүй болгочихлоо. Тэгээд санал би энэчээ тээ. Сая би өөрөө асууж амжаагүй байхгүй юу. Би өөрөө, би өөрөө саналаа өгч амжаагүй байхгүй юу. Тэгэхээр ингэчихье ахиад нэг санал. Түрүүн миний санал хураалгасан энэ санал дээр би эсрэг санал, миний төхөөрөмж ажиллаагүй учраас эсрэгээр орсон байгаад байгаа. Тэгэхээр энэ санал хураалтыг хүчингүй болгохоор ахиж санал хураая.

Саяынх дээр ялт ч байхгүй хураачихсан учраас дараагийнх дээр нь ороод явчихъя. Хоёр дахь санал байна.

Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.36.Сургуулийн барилга Сүхбаатарын аймгийн Түвшинширээ сумын 320 хүүхдийн суудалтай сургууль хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 6 тэрбум 9 зуун 618.3 сая төгрөг, санхүүжих дүн нь 4 тэрбум 555.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2 тэрбум 219.3 сая төгрөгөөр бууруулж, Соёл амралтын хүрээлэн Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын төсөвт өртгийг нь 14 тэрбум 926.4 сая төгрөг, санхүүжих дүнг нь 2 тэрбум 219.3 сая төгрөг хэмээн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн ийм санал орж ирж байгаа юм байна. Та тайлбарлах уу? Гараад явчихсан юм уу? Энэ санал дээрээ та тайлбар хэлэх үү? Тэгээд санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батсуурь. Энэ чинь тайлбар өгөх гээд байгаа юм биш үү та?

Ж.Батсуурь: Дарга аа эхний санал ч гэсэн нөгөө дэмжигдээд та өөрөө горимын саналаа хүчингүй болсон саналыг хүчингүй болгоно уу гэж асуухгүйгээр түрүүнд буруу асуугаад миний саналыг унагачихлаа л даа. Хоёр дахь нь яг адилхан. Бид нар эх үүсвэр дотроо царцсан барилгынхаа энэ мөнгийг нэгэнт үр ашиггүй зарцуулснаас явж байгаа төсөлдөө нэмж оруулъя л гэсэн ийм санал оруулаад байгаа байхгүй юу.

Тэгэхлээр энэ оруулсан саналыг дэмжиж өгнө үү гээд санал хураагаад өгчих та. Хүүш энэ юун байгаа юм. Үгүй ээ үгүй 19 онд очоод энэ дүнгээрээ дуусахгүй компани нь гэрээгээ цуцлаад дахь, уучлаарай царцсан гэдэг нь биш ээ, тийм. Энэ хар жагсаалтад ороод гэрээ нь цуцлагдчихсан юм. Тэгээд шинээр хийх гэж байгаа учраас. Тийм тэгэхдээ тэр дүн нь 19 оных болохлоор хүрэхгүй байгаа юм. Саналыг нь хураагаад өг.

Д.Батбаяр: Яачихъя тэгэх үү энэ төхөөрөмж ажиллаж байгаа үгүйг нь дахиад туршаад төстийн санал хураачихъя тэгэх үү? Төстийн санал хураалт явчихъя. Бүгдээрээ ахиж саналаа өгөөд үзээрэй.

Минийх болоогүй шүү. Би ер нь бол дэмжиж байгаа шүү дарга аа.

Одоо саяын гаргасан зарчмын зөрүүтэй санал дээр санал хураая.

Саяын санал 66.7 хувиар дэмжигдсэн байна.

Гурав дахь зарчмын зөрүүтэй санал.

Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.185.Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум цэцэрлэгийн 200 ортой барилга, хэрэгжих хугацаа 2018-2025 он, төсөвт өртөг нь 2 тэрбум 160 сая төгрөг, санхүүжих дүн 1 тэрбум 800 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг тэрбум 300 сая төгрөгөөр бууруулж, Төрийн аудитын газрын байр худалдан авах, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1 тэрбум 300 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батсуурь гэж байна.

Жавхлан сайдын микрофоныг.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд наадах чинь арай хэтэрлээ шүү. Наадах чинь Засгийн

газрын өргөн барьсан төсөл дээр наад Эрдэнэцагаан сумын чинь цэцэрлэг тэр бодвол магадлан хийгдсэн байх. Энийгээ бушуухан дуусга гээд төсөв тавиад наадах чинь ороод ирчихсэн юмыг та царцсан, барьсан гэж янз бүрийн нэр зүүгээд наадах чинь тэр төсөвт өртгийг нь, санхүүжих дүнг нь өөр тийш нь шилжвэл наадах чинь зарчмын хувьд огт болохгүй шүү.

Хэрвээ гэрээ нь зогссон гэж үзэж байгаа бол та тендер зарлаад, дахиж гүйцэтгэгчийг нь шалгаруулаад наад төслүүдээ бушуухан дуусгах та үүрэгтэй. Та наадхыг чинь санхүүжих дүнг нь бүтнээр нь авчихаар наадах чинь жинхэнэ зарчихсан шүү дээ. Өмнөх төсөл чинь ч гэсэн тэр. Та төсвийг нь булааж авснаар наадах чинь бүр бүтэн царцах үндэслэл үүсчхэж байгаа байхгүй юу. Үгүй ээ тэгээд наадхаар чинь хийлгэх ёстой байхгүй юу ажлыг нь та таарсан дүнгээр нь. Өмнөх та тэр, өмнөх төсөл чинь ч гэсэн одоо та хар аа жинхэнэ наадах чинь царцах болчихож байна. Тендер зарлах мөнгө байхгүй болчихож байна. Би наадах чинь, одоо наадах чинь Төсвийн байнгын хороон дээр санал хураагдана. Би тэр дээр дахиад хэлнэ шүү.

Д.Батбаяр: Та санал хэлээд дуусчихсан уу тээ?

Б.Жавхлан: Дууссан. Тэгээд энийг дэмжиж болохгүй төсөл шүү. Санал шүү энэ. Эсвэл та би, та санал хураалгахгүйгээр Батсуурь сайд аа та наадхаа өөрөө татаад авчихсан нь дээр дээ.

Д.Батбаяр: Саяын гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураая.

Саяын санал 33.3 хувь авч дэмжигдсэнгүй.

Дөрөв дэх зарчмын зөрүүтэй санал. Аль юм? Энэ юм уу? Энэ чинь юу гэж бичигдчихсэн юм? Энэ шиг ингээд

бичээд ирж болоогүй юм уу? Дарга аа таных л юм шиг байна шүү дээ. 10 дугаар сарын 27 гэж байна шүү дээ. Тийм. Зарчмын зөрүүтэй санал.

17.35 цаг

/2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр/

XVII.1.124.Олон угсаатны театрын барилга Ховд аймгийн Жаргалантын, санхүүжих дүнг 2 тэрбум төгрөгөөр бууруулж, XVI.1.1.4.Ногоон байгууламж бүхий... юу гэж байна?.. бүхий орчны тохижилтын ажилд Ховд аймгийн Мянгад сум, Зэрэг сум, Буянт гэсэн 3 сум юм уу тээ? 3 сум, санхүүжих дүн 2 тэрбум төгрөгөөр нэмэх гэсэн ийм зарчмын зөрүүтэй саналыг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж оруулж ирсэн байна.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

Тэгээд та энэ дээр санал хэлэх үү? Тэгвэл саяын зарчмын зөрүүтэй санал. Санал дээр санал хураая.

Саяын зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнгүй. 33.3 хувийн санал авчээ.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар гишүүн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Үгүй ээ үгүй. Өнгөрсөн одоо хуралдаан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Гишүүдэд баярлалаа.